Д.Ганбат: Ер нь албаны болон улсын нууц ингээд тамга тэмдэг дараад бас зах зухаас нь ярих шиг боллоо. Тэр 20 сая доллар энэ тэр гээд зөндөө их юм бий л дээ. Тэгээд энэ хуулийг баталснаар арай дээрдэх нөхцөл байдал бий болох уу? Засгийн газрын Хэрэг эрхлэх даргын Энхбаяр сайдын ярьж байгаагаар бол нөхцөл байдал бол маш хүнд байгаа юм байна. Энэ Засгийн газар нэг барьцаанд орсон юм шиг ингэж ажиллаж байгаад бол маш их харамсалтай байна. Энэ чинь Монгол төр, Монгол улсын Монголын ард түмэн өөрсдөө барьцаалагдаж байна л гэсэн үг шүү дээ. Тэгээд энэ авлига, энэ албан тушаалын хэрэг энэ их олон мөнгөний дүнтэй хэдэн их наядаар нь ярьдаг энийгээ тэгээд нууцын тамга дараад л тэгээд ярьж байдаг. Дараа нь энийгээ улс төрийн хэрэг болгоод л хоорондоо наймаацаж байдаг. Ийм юмнаасаа гарах боломж, бололцоо ийм юм байна уу байхгүй юу? Итгэж найдаж болох уу ямар байна?

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Харин тэгэх гэж л энийг төрийн болон албаны нууц, албаны нууц гэдэг зүйлийг байхгүй болгож байгаа юм. Тэгээд Засгийн газар дур зоргоороо тэнд юуг нууцлах, нууцлахгүйг мэддэг байдлыг нь халаад Улсын Их Хурал буюу ард түмний төлөөллийн дээд байгууллага төрийн нууцыг хуулиар нэр зааж баталдаг ийм болгож байгаа юм.

Нэгэнт Улсын Их Хурал хуулиар баталчих учраас одоо гүйцэтгэх эрх мэдэл, Засгийн газрын түвшинд ямарваа нэгэн сайд, дарга дур зоргоороо ямар ч юмыг энэ хуулиас гадуур нууцад авах нууцлах, ард түмний мэдэх эрхийг хаах боломжгүй болгох гэж байгаа юм. Хуулийн ерөөсөө гол зорилго нь энэ. Энэ хууль батлагдсанаар 800 гаруй албаны нууц 10 жилийн хугацаанд байсан нууц ил болж байгаа юм. Засгийн газар бол авлигатай тэмцэх бодлогын хүрээнд санаачилж оруулж ирж байгаа хамгийн том хууль бол энэ хууль. Би Хууль зүй, дотоод хэргийн.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд гүйцээж хариулъя. 1 минут.

Б.Энхбаяр: Хууль зүй, дотоод хэргийн сайдаар миний хувьд 2025 оны 11 сард томилогдсон. Томилогдоод 14 хоногийн дараа энэ хуулийн үзэл баримтлалыг би баталсан. Төрийн нууцыг энэ албаны нууц гэдэг ийм нууцалдаг юмнуудыг больё гэж. Энэ хуулийн үзэл баримтлалыг 2025 оны 11 сарын 19-ний өдөр баталсан байгаа. Та бүхэнд тараагдсан материал дээр харагдаж байгаа байх гэж бодож байна. Тийм учраас зөвхөн хэрэг учрал ярихаас гадна энэ авлигын гэмт хэргийн үүр уурхай, шалтгаан болсон нууцалж байгаад хулгай хийдэг энэ суурь шалтгаан болсон тэр нууцлаад байсан хуулийг нь өөрчилж, сая хэлсэнчлэн 800 гаруй тэр албаны нууцын тамгатай байсан зүйлийг ил болгох гэж байгаа юм. Улсын Их Хурлаас гадуур Засгийн газар ямар ч дарга нууцлах боломжийг энэ хуулиар хаах гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Өөрийнхөө хэмжээнд боломж бололцоогоороо бас нөхцөл байдалтай энэ хэмжээнээс илүү гарч ажиллаж чадахгүй л байгаа байх л даа. Харамсалтай байна. Гэхдээ энэ олон нууцын тамга дарж ингэж хулгай хийсэн, завшсан, шамшигдуулсан татвар төлөгчдийн мөнгийг, Монголын ард түмний өмч хөрөнгийг өнөөдөр ингээд ард түмний 50 хувь нь ядуу, 30 хувь нь нэн ядуу амьдарч байгаатай энэнтэй холбоотой байх. Тэгээд ямар хариуцлага яригдах вэ энэний дараа, энэний үр дүн ямар байх вэ? Ер нь одоо тэгээд энэ хариуцлага ярьж байгаа ийм юм байна уу байхгүй юу? Бүгд л тэгээд завшаад л ингээд л яваад байна уу?

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад нэмж хариулъя Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Би бол хариуцлагыг дээрээсээ эхлэх ёстой гэж боддог. Тийм ч үйлдлээр өнөөдрийг хүртэл ажиллаж ирсэн. Улсынхаа Ерөнхий сайд байсан, өөрийн намын дарга байсан, өөрийн намын Ерөнхий нарийн бичгийн дарга байсан хүмүүстэй холбоотой олон 10 сая долларын үйл баримтыг баримтаар дандаа нотолж ярьж, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Энэ хүмүүсийн зүгээс ярьдаг зүйлүүд нь бол дандаа гүтгэлэг. Дандаа тийм пропаганда тийм юм хийдэг. Хуулийн байгууллагууд бас гар ... -дөө эрддэг юм уу яадаг юм. Манай хуулийн системд харагдаж ч үзэгдээгүй үйл явдал болж байгаа шүү дээ. Тэр Даваадалай гэж нөхрийн кэйс бол өөрийнхөө тэр эхнэрийн хамаарал бүхий дансаар 5.5 тэрбум төгрөг шууд шилжүүлж авна гэдэг бол тэнэг зориг шүү дээ. Энэ хамгаалалтдаа .../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн асуулт асууна. Дараа нь Анар гишүүн байгаа.

Ж.Энхбаяр: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо тэгэхээр бид нар энэ гадаад бодлого, аюулгүй байдал гэдэг өнцгөө барьж энэ асуудалд хандах ёстой. Нөгөө Нэгдсэн Үндэсний Байгуулга төвтэй олон улсын дэг журам чинь нурж унаад олон улсын гэрээ, эрх зүй ер нь олон асуудал бол үйлчлэл нь хүндрээд байгаа ийм цаг үе ирж байгаа. Тэгээд их гүрнүүдийн энэ түрэмгий хэв шинжтэй бодлогыг би дэлхийгээрээ л мэдэрч байна шүү дээ одоо яг. Энэ хувь хүний асуудал биш энэ бол системийн асуудал. Зөрчил гүнзгий, дунд хугацаанд үргэлжилнэ. Багаар бодоход 10 жил ийм дэлхийн ийм сөргөлдөөн, мөргөлдөөн энэ хямралт байдал руу явах нь тодорхой байж байгаа ийм цаг үед манайх шиг ийм хөгжиж байгаа орнууд байгаа юм. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлоготой манайх шиг орнуудад бол нэлээн энд оршин тогтнох, тусгаар тогтнол, язгуур эрх ашигтай холбоотой олон сорилтуудыг бий болгож байгаа. Энгийг бид нар маш сайн бодно.

Нөгөө талаасаа энэ улс орнууд, их гүрнүүд нөлөөний хүрээгээ хуваах томоохон сөргөлдөөний хүрээнд нөгөө уламжлалт бус арга техникүүд маш хүчтэй нэвтэрч байгаа. Ард иргэдийн үзэл санааг нь нөлөөлөх, эсрэг чиглүүлэх, хооронд нь төр, ард түмний итгэлийг сулруулах, дотоод шашин, үнэт зүйлийн зөрчлийг үүсгэх. Тэгээд л энэ сүүлийн үед энэ технологи, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаанд суурилсан нийгэм ард иргэдээс чиглүүлсэн энэ системтэй ажиллагаанууд ийм байдлууд бүүр ингээд бүүр илт идэвхтэй болж байгаа.

Тэгэхээр ингээд нууцын асуудал ялангуяа манайх шиг улс төр, дипломатын аргаар улс орныхоо аюулгүй байдлыг хамгаалах үндэсний аюулгүй байдлын гол үзэл баримтлал бүхий улс орны хувьд нууцлах олон асуудал байгаа юм. Тэгэхээр энэ 800 гаруй хуулийг ил болгоод нөгөө нууцалсан нууцлалыг ил болгоод явна гэж

байна. Тэгэхээрээ нууцын асуудал, төрийн нууцын аюулгүй байдлын асуудал Тагнуулын ерөнхий газар хариуцаж байгаа. Ажлын хэсэгт байна, асуух асуулт байгаа юм. Энэ жагсаалт ингэж хуулиар батлах нь хэр оновчтой гэж үзэж байна? Ер нь олон улсын жишээ ямар байдаг юм? Ер нь цаашдаа нууцын асуудлууд бүгд энэ Их Хурлаар орж батлагддаг гэдэг чинь тухайн зорилт нь өөрөө ингээд ил тод болох буюу үндсэн нууцлалын чадвар, нөгөө шаардлагаа алдах нэг ийм эрсдэл байна уу даа л гэж юм зүгээр бодол төрж байна.

Тэгэхээр мэдээллийн нууцлалыг мэдээж анхаарах, илүү бодлогын түвшинд хамгаалж зохицуулах шаардлага бидэнд байна. Ялангуяа гадаад бодлогын чиглэлээр. Тэгэхээр тэр аж ахуй, бизнесийн харилцаатай нууцалж байж түрүүний Ганбат гишүүний яриад байгаа энэ янз бүрийн ашиглалт хулгай зэлгийтэй холбоотой асуудал бол тодорхой.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Нэмээд 1 минут өгье. Асуултаа гүйцгээж асууя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр энэ яг тэр аж ахуйн асуудлууд мэдээж нууцалж хавтгайруулсан ийм зохисгүй байдал байгаа болоод хууль Засгийн газраас өргөн барьж байгаа. Тэгэхээрээ яг энэний хүрээнд бид нарын яг нууцалбал зохих гол бодлогын юмнууд маань тэгээд шинэ шинэ хуулиар л нууцлаад эхэлнэ гэдэг чинь л цаг алдах, нууцлах агуулга гээд олон юм үүсчих л эрсдэл байгаад байх юм. Тэгээд энэ Тагнуулын ерөнхий газрын Дэд даргаас асуугаадахъя. Ер нь ямар байр суурьтай, олон улсын жишиг ер нь яаж яваад байна вэ гэж. Ер нь яавал зөв бэ гээд. Жоохон болгоомжтой хандаж, бүгдээрээ сайн нягталъя л гэсэн ийм санал гаргаад байна гэж.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хэн хариулах вэ? Ажлын хэсгээс хариулъя Тагнуулын дарга. Индрийн микрофон өгье. Индрийн микрофон. Индрийн микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Асуултад хариулъя. Энхбаяр гишүүний асуултад хариулъя Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, бригадын генерал Бат-Эрдэнэ. Жагсаалт батлах тухай хуультай холбоотой асуулт асуулаа гэж ойлгож байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг шинэчлээд Төрийн нууцын тухай хууль болгон мөн жагсаалт батлах тухай хууль нэмж дагаж орж ирж байгаа юм. Хуучин Засгийн газрын тогтоолоор байсан 247 дугаар тогтоол маань хууль болж орж ирж байна гэж ойлгож болно.

Жагсаалтыг хуулийн хүрээнд би сая яг 5 хүрээний хүрээнд хуульчилж жагсаалтыг хийсэн. Энхбаяр гишүүн бол олон улсын практик талаас судалгааны юм байна уу гэж асуулаа. Энэ дээр бол бид төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт батлах бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа субъектийг тодруулах зорилгоор үүний хүрээнд судалгаа хийсэн. Нийт.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Микрофоныг хариулт бүтэн 4 минутаар өгөхөөр байгаа. Хариултыг, индрийн микрофон 3 минутаар.

Б.Бат-Эрдэнэ: Нийт 18 улсын төрийн нууцын хууль тогтоомжийг судалж үзэхэд ерөнхийлөгч, эрх бүхий байгууллага баталдаг төвлөрсөн загвартай 4 улс, Засгийн газар, эрх бүхий сайд, албан тушаалтан салбарын хэмжээнд баталдаг 14 улс байгаа. Олон улсын жишгээр бол нууцад хамаарах мэдээллийг тодорхойлохдоо мэдээллийн жагсаалтыг бол хуулиар бас, хуульд тогтоосон

шалгуур хүрээг үндэслээд эрх бүхий гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага баталдаг ийм загвар зонхилж байгаа.

Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17-д төр, түүний байгууллагаас хууль, ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасантай уялдуулаад энэ Жагсаалт батлах тухай хууль орж ирж байгаа гэж ойлгож байгаа.

Жагсаалт батлах тухай хуулийн хүрээнд бас сая нэмж хэлэхэд энэ дээр жагсаалт маань бол байнга хувьсан өөрчлөгдөж байдаг нэг ийм бэрхшээл бий. Төрийн нууцад хамаарах мэдээллийг өөрчлөх хэрэгцээ шаардлага нь бол байнга үүсэж байдаг. Эдийн засаг, геополитик зэрэг дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болдог ийм онцлогтой хууль байгаа, онцлогтой асуудал. Тэгэхээр энэ асуудлын хүрээнд бас ажлын хэсэг хүрээнд нухацтайгаар бас ярилцах шаардлагатай байгаа гэж ойлгож байгаа манай байгууллагын хувьд.

Өөрөөр хэлбэл, уян хатан байдал, хурдан шинэчлэгдэх боломж талаасаа мэдээллийг нууцад хэрхэн оруулах вэ, гаргах вэ, процесс ямар байх вэ гэдэг дээр нэлээн ярилцах ийм асуудлууд тулгарах байх гэж үзэж байгаа.

Хуулийн ерөнхий зохицуулалтын хувьд бас санал хэлэхэд 1995 онд анх Төрийн нууцын тухай хууль батлагдсан. 2006 онд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль гэж манай улсад бол байсан. 2006 оны Жагсаалт батлах тухай хууль 2016 он хүртэл үргэлжилсэн. Энэ хугацаанд энэ хууль бол яг 4 хүрээгээрээ хууль маань нууцын маань хууль зохицуулагдаж байсан боловч хуулийг нууцалсан баримтыг ил болгох, нууцаас хасах, нууцлалд авах энэ процесс нь бүрэн тусгагдаагүй байсан ийм асуудлууд байгаа. Тийм учраас 16 оны 12 сарын 01-нд хуулийг шинээр батлаад 17 онд энэ жагсаалтаар, Засгийн газрын жагсаалтаар төрийн нууцад авах, хасах, ил болгох асуудлуудыг ингээд зохицуулж ирсэн.

Г.Тэмүүлэн: Нэмж 1 минут өгье хариултыг гүйцээе.

Б.Бат-Эрдэнэ: Байсан. Энэ хугацаанд тагнуулын байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангах явцад 17 оноос хойш бол 242863 дуусгавар болсон мэдээлэл, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас цаашид нууцлах шаардлагагүй болсон 26116, хууль батлагдсанаар ил болсон 3689, үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон 1203 мэдээллийг бол ил болгосон ийм тоо баримт байгаа. Илтгээд дууслаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд нэмж тодруулъя.

Ж.Энхбаяр: Би ажлын хэсгийн ахлагчаас асуугаадахъя. Жишээлбэл, стратегийн зориулалттай ашигт малтмал, тухайн ашигт малтмал сонирхож байгаа улс орнуудын байр суурь, шашин шүтэх, эс шүтэх асуудал, сүм хийдийн харилцааны асуудал гээд нэг тухайн үедээ бодлого тодорхой болтол нууцлах, бодлогын боловсруулалт хийх гээд ийм процессууд нэлээн юм гарна. Амьдрал баян хойно зөндөө л олон сэдэв байгаа. Гэтэл нууцыг нь ингээд жагсаалтаар хаачихдаг. Тэр жагсаалтад ороогүй байдаг нууцлах асуудал тэгээд тэр нууц сахих шаардлага үүсдэг. Тэр маань өөрөө ингээд хуулийн зөрчил рүүгээ ороод Их

Хурлаар нэгэнт хуульчлаад баталчихсан юм чинь нууцад авч болдоггүй нэг иймэрхүү нэг юм үүсэх вий. Тийм эрсдэлүүдийг юу гэж тооцож байна вэ л гэдгийг Энхбаяр сайдаас асууя даа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд асуултад хариулъя. Б.Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Төрийн нууцын жагсаалтыг яг хуулиар тогтоогоод ингээд албаны нууц гэдэг зүйлийг байхгүй болгоход албаны нууцад одоо байгаа 800 гаруй мэдээлэл дотор яг төрийн нууц ч биш тэгэхдээ шууд ил тод нээлттэй болгоход бас манай улсын хувьд, ялангуяа төрийн өмчийн компаниудын бизнес, мэдээлэлтэй холбоотой ийм мэдээллүүд бол бас ил болно.

Мэдээж бизнесийн харилцаанд бас оролцож байгаа гэдгийгээ бид үргэлж бодох ёстой даяарчлагдсан. Бид нар бүх мэдээллээ ил тод болгох нь мэдээж аюулгүй байдал талаасаа эрсдэл учруулна. Испани.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Гүйцээж хариулъя Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Испанийн хуульч Хосе Ортега Гассет гэж хуульчийн нэг хэлсэн үг байдаг юм. Нээлттэй байдал бол итгэлцлийг бий болгодог. Тэгэхдээ чи өөрийнхөө дайсанд нээлттэй бүх юмаа ил тод болгоно гэдэг бол чи дайсандаа ялагдах үндсээ өөрөө бүрдүүлж өгч байна гэдэг ийм үг байдаг. Хэзэр тоглож байгаа хүмүүс ч гэсэн модоо дэлгэж байгаад хэзэр тоглодоггүй. Модоо дэлгэж байгаад хэзэр тогловол ялагдана. Тийм учраас энэ 2 дүрмийг бас сэрэмжлүүлж хэлж байгаа асуудлыг би Улсын Их Хурлын ажлын хэсгийн шатанд зарим мэдээллийг хаалттай байдлаар ажлын хэсэгт танилцуулах замаар би шийдвэрлэх боломжтой байх гэж ингэж бодож байгаа.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя. Анар гишүүний микрофоныг өгье.

Ч.Анар: Энэ Төрийн болон албаны нууцын хуулийг зайлшгүй шинэчлэх шаардлагатай. Энэ Энхбаяр сайдын яриад байгаа шиг энэ албаны нууцад аваад завхруулдаг асуудал зөндөө байгаа. Бүүр маш их шүү. Ялангуяа энэ Засгийн газрын тогтоолгүй, Тагнуулын ерөнхий газрын жагсаалтад байхгүй бичиг баримтуудыг улсын нууцад авчихдаг. Тэгээд нууцын тамга, тэмдгээр бичиг баримтаа ирүүлчихдэг. Тэгээд нөгөөхийг нь хэзээ нууцад авсан юм, тогтоол нь хаана байгаа юм, жагсаалтад байгаа юм уу гээд тодруулга авахаар байдаггүй. Тэгсэн мөртөө ингээд маш нууцаар бичиг баримт нь хүрээд ирдэг. Их Хурал өөрөө хянан шалгах эрх, бололцоо байхгүй болчихсон. Тэгээд энд нөгөө Их Хурлын үндсэн чиг үүрэг нь байхгүй болчихсон. Энд бол нөгөө яг заавал ч үгүй төрийн нууцад авах шаардлагагүй материалууд байгаа байхгүй юу. Энхбаяр сайдын ярьж байгаа.

Тэгэхээр энэ албаны нууцад авч байгаа процесс нь ойлгомжгүй, тодорхойгүй. Хойноос нь хөөцөлдөөд явахаар хэзээ, яагаад нууцад авсан юм бэ гэхээр хэн ч мэддэггүй. Энэ яг асуудлууд бол манай ажлын хэсэг дээр маш олон газар байна. Нийслэл дээр нууцад авсан юм байна. Хиймэл дагуул дээр нууцад авсан юм байна. Энэ газрын тосыг жишээ нь Хөгжлийн банкин дээр нууцад авчихсан. Газрууд нь очоод шалгах гэхээр төрийн нууц гээд шалгуулдаггүй. Ямар учраас төрийн нууцад авчихсан юм. Одоо тэгээд л хэдэн оноос хойш мөнгө нэхэж байгаа юм. Газрын тосны үйлдвэр болтол мөнгө нэхээд байгаа шүү дээ. Тэгээд яг үр дүнтэй ашиглаж байгаа юм уу, яаж байгаа, ийж байгаа гээд хяналт тавих гэхээр

ямар процессоор нууцад авсан нь тодорхойгүй. Тэгээд Тагнуулын ерөнхий газраас хэдэн оны, хэдэн сарын ямар Засгийн газрын тогтоолоор нууцад авсан юм бэ гэхээр байхгүй гээд байдаг. Энэ гажуудлыг бол засах нь зүй зохистой.

Гэхдээ энэ шинэ орж ирж байгаа хуулийн төсөл дээр бол техникийн хувьд бол маш олон засварууд бол харагдаж байна. Хуулбар, хуулбарлах, хувилах, санаатай, санамсаргүй гэдэг техникийн нэр томъёонууд орхичихсон байна. Тэгэхдээ хамгийн их санаа зовж байгаа зүйл бол нэг тал руугаа жишээ нь төрийн нууцыг 126 гишүүнд ингээд жагсаалтаараа батална гэхээр чинь энэ чинь нууц болох юм уу? Зайлшгүй шаардлагатай зүйлээ нууцдаа нууцыг хамгаалагчийн эрх үүргийн цар хүрээ чинь томсож байна шүү дээ. Тэгээд энд чинь өөрөө Их Хурлын чуулган руу орж ирэхээр улс төржилтөд нь яваад маш олон аюулгүй байдлын чиг шугам, батлан хамгаалах чиг шугамаар зарим зүйлүүдийн нюансыг нь ойлгохгүй зүйлүүд их, Их Хурлын гишүүдийг нь ч ойлгохгүй, цаанаа гадаад бодлогын, аюулгүй байдлын, олон улсын хамтын ажиллагааны олон комплекс бодлоготой асуудлууд бас нууцад орж ирэх ёстой байна. Өөрөө Их Хурлаар батлагдах болохоор энэ чинь бол ер нь би бол энэ бас нөгөө талдаа хэт нээлттэй болоод нууц ч болчхож байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Тагнуулын ерөнхий газар ямар байр суурьтай байгаа юм бэ? Та бүхэн чинь төрийн нууцыг хариуцах ч юу байна. Нөгөө хүмүүс маань дархан эрхтэй гишүүд шүү дээ. Энэ дахиад тодруулъя.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Анар гишүүний хэлж байгаа энэ асуудлыг бас Байнгын хорооны гишүүд их анхааралтай бас хүлээж авах хэрэгтэй байгаад байгаа юм. Ер нь бол Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэлэлцүүлгийг уг нь хаалттай хийчихвэл их зүгээр байгаад байгаа юм. Горим гаргаад. Тэгээд эрхэм гишүүд журмын дагуу асуугаад тэгээд ингээд хэлэлцвэл бид нар Төрийн нууцын хуулийг нээлттэй хэлэлцээд байгаа байхгүй юу. Тийм. Төрийн нууцын хуулийг нээлттэй. Тэгэхээр чинь нөгөө хариулт бол үргэлж дутуу өгөгдөж таарна эрхэм гишүүдэд.

Тийм учраас саяын бас Анар гишүүний санаж чилээж байгаа асуудал дээр хууль санаачлагч ч гэсэн адил ийм байр суурьтай бас санаа чилээлт адилхан л байх.

Г.Тэмүүлэн: Амар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Горимын санал гаргаад явахаар чинь нэг бүх л юмаа нууцад авлаа гээд л хардлага. Тэгэхдээ энэ төрийн нууц тэгээд нууцын жагсаалтаа Их Хурлаар батална гэхээр яг бас энэ хууль чинь өөрөө их сонирхолтой болчхоод байна л даа. Нууцаа нээлттэй хэлэлцээд жагсаалтыг нь батална гэхээр чинь энэ чинь нууц мөн юм биш юм уу? Тийм, тэгэхээр энэ дээр Тагнуулын ерөнхий газар өөрснөө энэ хариуцаж байгаа асуудал байгаа.

Дээрээс нь нууцын, төрийн, үндэсний аюулгүй байдалтай холбогдолтой, батлан хамгаалахтай холбогдолтой, гүйцэтгэх ажиллагаатай холбогдолтой нууцуудыг энэ Их Хурлын гишүүд маань нууцалж чадах уу, хамгаалж чадах уу? Тэр нууц задруулсан дээрээ Их Хурлын дархан эхээрээ өөрснөө хамгаалагдчих юм биш үү? Хариуцлага яаж оногдуулах юм? Ер нь манай улс чинь нуух юм байхгүй боллоо шүү дээ. Бүх улс төр, нийгмийн байдал, улс төрийн нийгмийн

байдлаа сонсголоор бүгдийг нь зарлаж байна. Эдийн засгийн байдлаа зарлаж байна.

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ? Тагнуулын ерөнхий газар. Тэгье, индрийн микрофоныг өгье. Шаардлагатай бол Хууль зүйн яамнаас нэмээд хариулаарай. Асуултад хариулъя микрофон өгсөн байна. Битгий дараарай.

А.Бат-Эрдэнэ: Анар гишүүний асуултад хариулъя. Хууль маань яг 5 хүрээнийхээ хүрээнд задлаад жагсаалтаа хийж байгаа. Жагсаалт дээр бол үнэхээр нарийвчилсан юмнууд яригдана. Энэ бол бас чухал асуудлууд байгаа. Жишээлбэл бид ингээд Батлан хамгаалах яамны чиглэлээр асуудлууд гэх юм бол энэ шиг нэлээн хэдэн жагсаалтууд гаргаж ирнэ. Энэ дотор нууцад авах болсон үндэслэл, шаардлага, шалгуур үзүүлэлт ямар зэрэглэлд байх юм, ямар хугацаанд байх юм, алдагдвал бусдын олз бол ямар хохиролд бэрхшээл учрах юм бэ гэдгийг бид салбар бүрээр нь ингээд судалж гаргасан байгаа.

Тэгэхээр бол цаашдаа бол төрийн нууцын жагсаалтын асуудлыг ярихдаа бол зайлшгүй хаалттай ярилцах шаардлагатай гэж бодож байгаа. Яагаад гэвэл улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, бодлоготой холбоотой асуудлууд яригдана. Хуулийн маань яг 1.3-д гадаад бодлогын асуудал, 2-т эдийн засаг, 3-д нь батлан хамгаалах салбарын асуудал, 4-д нь хууль сахиулах асуудал, 4-д нь техник технологийн гэсэн ийм 5 хүрээнд бид хувааж яг хуулиа ингэж хийж, үүнийхээ дагуу жагсаалт гаргаж байгаа. Тэгэхлээр энэ дээр бол цаашид бол яг нарийн асуудлуудыгаа хаалттай хэлэлцэх нь зүйтэй гэсэн байр суурийг Тагнуулын ерөнхий газраас илэрхийлж байгаа.

Жагсаал тогтоох хуулийн төсөлд бол нийт 202 мэдээллийг бид нар одоогоор тусгаад байгаа. Энэ мэдээллийг задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, аюул занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц болон хүнд үр дагавар бий болох хүний амь биед аюул учруулах, батлан хамгаалах чадавхыг сулруулах, мөн үндэсний аюулгүй байдал хангах үйл ажиллагаанд хохирол учруулах, эсвэл төрийн нууцын онц чухал, нууц, маш нууц мэдээллийг задруулах нөхцөл бий болгох эрсдэл бүхий мэдээллүүд гэж ойлгож болно энэ 202-ыг. Мэдээллийн хувьд бид нар урьд нь байсан 574 мэдээллийг агуулгын хувьд, давхцалын хувьд салбар хоорондын уялдааг хангах, мөн шинээр гарч байгаа нэр томьёо, үг хэллэгийн хувьд нийцүүлээд ингээд 200 гаран болгочхоод байгаа. Энэ мэдээлэл цаашаа бол бас нарийвчлагдаад ингээд явах юм байгаа юм.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн хүрээнд мэдээлэл, тухайн мэдээллүүдийн жагсаалтад туссан үндэс, шалгуур, мэдээллийн хүрээнд үүсэж хөдлөх баримт бичгүүд, мэдээллийн төвлөрөл зэргийг илэрхийлэх боломжтой бөгөөд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг хангах зорилгоор зайлшгүй нууцлах шаардлагатай, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хамаарах төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухааны энэ технологийн аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхыг илэрхийлэх тагнуул, сөрөг тагнуул, гүйцэтгэх ажлын болон үндэсний аюулгүй байдал хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд хамаарах мэдээллүүд бас.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Нэмж хэлэх мэдээлэл байна уу? 1 минут нэмээд өгчихье. Гүйцээгээд хариулчих.

А.Бат-Эрдэнэ: Иймд манай байгууллагын байр суурь төрийн болон албан нууцтай холбоотой асуудлыг нууцын горимоор цаашдаа хэлэлцэж, тал бүрээс нь бас ярилцах нь зүйтэй гэсэн ийм гишүүдийн саналтай санал нэг байна. Илтгээд дууслаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Дахиад тодруулъя. Дахиад ерөөсөө л нөгөө яг энэ нөгөө нууцтай холбоотой юм шиг болохоор хариулж болох байх гэж бодож байна Энхбаяр сайд ажлын хэсгийн ахлагч. Энэ төрийн нууцтай холбоотой сая дурдаж байгаа үндэсний аюулгүй байдал, тагнуулын үйл ажиллагаа, гүйцэтгэх ажиллагаа, батлан хамгаалахтай холбогдолтой асуудал, гадаад хэрэг, бодлоготой холбогдолтой асуудлуудыг батлахад Их Хурлын гишүүд энэ салбарынхаа бүгдээрээ мэргэжилтэн, мэдээлэл, мэдлэг, мэдээлэл байхгүй. Тэгэхээр ойлгож баталж чадах уу улс төржихгүй юү? Бүх гишүүд мэдчихээр нууц биш болох юм биш үү? Дахиад төрийн нууц задруулах юм бол хариуцлага хүлээх тогтолцоо бол байхгүй шүү дээ манайд Их Хурлын гишүүдэд. Дахиад Тагнуулын ерөнхий газар та процесс яриад байна л даа.

Би асуух гээд байгаа юм нь Их Хурал дээр бүх нууц орчихоор та бүхэн энэ хяналтаа тавьж чадах юм уу? Энэ чинь эргээд зөрчилдөөд байгаа юм биш үү? Хэтэрхий нээлттэй, хэчнээн нууц горимд байсан ч гэсэн хяналт тавих чинь хүндрэлтэй болох юм биш үү?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Хууль зүйн яамнаас Хууль зүйн яамны дэд сайд Мөнх-Эрдэнэ сайд хариулна.

Д.Мөнх-Эрдэнэ: Анар гишүүний асуултад хариулъя. Энэ төрийн нууцын жагсаалт батлах хууль ер нь бол төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээ хязгаарыг тогтоож өгч байгаа юм. Сая манай Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга танилцуулж байгаа. Энэ хүрээ хязгаарын хүрээнд ямар мэдээлэл, юу нууцад хамаарах вэ гэдэг нь тусдаа маш нарийн шалгуур үзүүлэлттэй гарч ирдэг. Энийг бол Тагнуулын ерөнхий газар зохион байгуулж хариуцаж явдаг.

Тийм учраас жишээ нь 2017 онд Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан энэ төрийн нууцын жагсаалт батлах бол мөн ялгаагүй энэ Нууцын жагсаалтын хуультай адилхан Ерөнхий хүрээ хязгаарыг л тогтоож өгч байгаа. Харин бид энэ давхардсан байсан 574 төрийн нууцын жагсаалтад багтсан тэр хамаарах мэдээллийг давхардсан, ач холбогдлоо алдсан гэдэг агуулгаар Тагнуулын ерөнхий газар холбогдох энэ нууц хариуцсан 33 байгууллагатай нэг бүрчлэн ажиллаж хүрээ хязгаарыг нь 200 болгож оруулж ирж байгаа. Энэний цаана хэчнээн ямар мэдээллүүд, хэчнээн хуудас, ямар материал, эд зүйлс, объект нууц байх вэ гэдгийг бол Тагнуулын байгууллага хариуцаж тусгайлан шалгууртаа шалгуур, тусгай шалгуураар шалгаж, үнэлгээ хийж ингэж цааш нь нууцын тэмдэг дарж авч явдаг.

Дараагийн нэг асуудалд бол энэ төрийн нууцыг хамгаалах гол асуудал бол нэг хууль, эрх зүйн хувьд бол Эрүүгийн хууль тогтоомж, Зөрчлийн хуулиар хамгаалж байгаа. Өөрөөр хэлбэл, төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан, төрийн нууцтай танилцсан эрх бүхий албан тушаалтнууд төрийн нууцыг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд, эс үгүй бол эх орноосоо урвах, тагнуул хийх гэх мэт тодорхой хэргүүд дээр энэ төрийн нууцын мэдээллийг задруулахтай холбоотой

ийм гэмт хэргийн бүрэлдэхүүн, шинжийг хуульчилсан байдаг. Ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдэг. Тэгэхлээр энэ Эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалж байгаа.

Нөгөө талаасаа Засгийн газар тагнуулын байгууллага, тусгай албад бол энэ төрийн нууцыг хамгаалах ажлыг хариуцан зохион байгуулж байдаг. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Төрийн нууцын тухай хууль орж ирж байна. Энхбаяр сайд аа ийм тодруулах зүйлүүд байна. Үндсэндээ би энэ шинэчилсэн найруулга өөрөө орж ирж байгаа учраас бид нар магадгүй сая сүүлийн 10 жилийн энэ алдаатай, оноотой, хулгайтай, зэлгийтэй, авлигал, хээл хахуультай холбоотой энэ төрийн нууцтай холбогдсон энэ асуудлуудаа бол бид нар нэг дор цэгцлэх ёстой гэж хараад байгаа юм. Одоо энэ хуулийн шинэчилсэн найруулгын дагуу төрийн нууцын тамга дараад асуудлаас мултардаг, хариуцлагаас чөлөөлөгддөг энэ цаг бол өнгөрөх ёстой шүү гэж хараад байгаа юм.

Тэгэхээр магадгүй тэр нууцалсан нууцын цаана авлигал авсан этгээд байгаа бол ямар нэг юу гэдэг юм авлигал, хээл хахуультай холбоотой асуудал цаана нь үүссэн бол энэ дээр бол хариуцлага тогтоодог энэ тогтолцоо бол байх ёстой гэж хараад байгаа юм. Тэгэхээр би нэгд хоёр, гурван зүйлийг асуух гээд байгаа юм.

Жишээ нь бид нар хүссэн ч, хүсээгүй ч өнгөрсөн магадгүй сүүлийн 10 жилийн хугацаанд энэ явцуу эрх ашгаа, ашиг сонирхлоо ингээд нууц нэрийн доор, тамганы цаана ингээд нуудаг, орогнодог үүр уурхай нь бол хүссэн, хүсээгүй бас болчихоод байгаа юм нэг талдаа. Тэгэхээр би нэгд асуух гээд байгаа зүйл нь нэг ийм зүйлийг асуух гээд байгаа юм.

Нэгдүгээрт, энэ нууцлах үйл явцыг маш нарийн хяналттай бол болох ёстой байгаад байгаа юм. Нууцлах үйл явцыг нэгдүгээрт. Тэгэхээр энэ нууц ангиллын шалгуурыг бүрэн дүүрэн нарийвчилж чадсан уу гэдэг асуултыг асуух гээд байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарх нь юу нууцлаад байна вэ гэхээр энэ чинь өөрөө баримт бичгүүдээ, үйл ажиллагаагаа, шийдвэрүүдээ, бүүр цаашлаад төсвөө нууж байгаа. Төсөв, хөрөнгө, санхүүжилтүүдийг нууж байгаа асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор аливаа төсөв, хөрөнгө, санхүүжилттэй холбоотой асуудалд төрийн нууцын тамганы цаана аудитын болоод хөндлөнгийн ямар нэг хяналтын цаана гадуур үлдэх ёсгүй шүү гэж хэлэх гээд байгаа юм. Энийг шийдэж чадаж байгаа юу? Тэгэхээр аудит болоод тэр санхүүгийн аливаа тэр байгууллагууд нь тухайн тэр нууцын шийдвэрийн цаана ямар нэг юу гэдэг юм авлигын шинж чанартай зөрчил байх юм бол тэрийг саадгүй шалгадаг, санхүүгийн баримтуудыг үздэг, хардаг энэ эрх бол үүгээр би бас нээгдэх ёстой гэж хараад байгаа юм.

Дээрээс нь хууль бусаар нууцалсан аливаа тэр этгээд байх юм бол тэрийг юу гэдэг юм гэмт хэрэгт тооцох энэ хариуцлагын санкц байгаа юу үгүй юу? Орж ирж байгаа юу үгүй юу? Хэн нэг нь юу гэдэг юм хууль бусаар нууцалсан, манайд ийм жишээнүүд зөндөө гарсан. Тэгэхээр энэ дээр яг ямар юутай байна?

Хоёрдугаарт, төрийн нууц нэрийн доор төсвийг нууцад авдаг асуудлууд байгаа юм. Тэгэхээр юу гэдэг юм нууцын зардалд оруулах зардлууд өөрөө ямар байх юм? Энийг нарийвчлах энэ зохицуулалтуудыг хийж чадаж байгаа юу үгүй юу? Зөвхөн баримт бичиг, үйл ажиллагаа гэхээсээ илүүтэй одоо бол төсөв дээр ямар

нэг нэрийн доор нууцалдаг, түүн дотроосоо нууцад нэрийг нь оруулсныхаасаа хамаараад аливаа тендерээс зугтаадаг, аудит, шалгалтаас зугтаадаг асуудлууд байгаа. Энийг бас нарийвчилж зохицуулалт хийж чадах юм уу? Тэгэхээр энэ нууцлах, төсвийг нууцлах энэ процессыг бас бид нар тодорхой хяналтад оруулж, зөв зохистой, зүйтэй асуудлууд нь ордог, тодорхой зөвхөн үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болоод тагнуулын үйл ажиллагаатай холбоотой зардлууд нь л үйл ажиллагаанууд нь л ордог энэ зохицуулалтуудыг нь хатуу нарийвчилж өгөх зүйл хийхгүй бол өнгөрсөн хугацаанд бол ямар зүгээр нэг байшин барилгыг, дэд бүтцийг, зүгээр байх ёстой зардлуудыг тендер, болоод худалдан авалтын үйл ажиллагаанаас, хуулиас зугтаалгахын тулд бол оруулдаг ийм жишээнүүд бол гарсан.

Гуравдугаарт, эдийн засгийн гэрээнүүд өөрөө бас нэг талдаа нээлттэй болох ёстой гэж хараад байгаа юм тодорхой. Тэгэхээр энд бол бид нар хуучин болсон жишээнүүд бол томоохон төсөл, хөтөлбөр, мега нэртэй худалдан авалтууд, тендерүүд бол нуугддаг энэ асуудлууд бол байсан. Энэ бол цаашдаа бол эдийн засгийн гэрээ энэ ажиллагаанууд бол илүү ил тод, нээлттэйгээр бол явах ёстой гэсэн ийм бол байр суурьтай байгаа. Энэ бол үндсэндээ тогтолцооны гажуудал байсан. Хуулийн цоорхой байсан. Одоо тэгэхээр бид нар төрийн нууц нэрээр халхавчилж шийдвэр гаргадаг, хулгайг нуудаг энэ тогтолцоог бол нэг талдаа бас хаах ёстой гэж бол үзээд байгаа юм. Энэ асуудлууд дээр хариулт авъя.

Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Энэ хууль дээр хатуу зааж өгч байгаа нэг асуудал байгаа. Тэр нь бол хөгжлийн дэд бүтцийн, улс орны эдийн засгийн хөгжлийн том төслүүдийг нууц хэлбэрээр шууд худалдан авах хийхийг энэ хуульд шууд бичээд хориглож байгаа. Том төсөл гэдгийн ард том хулгай байна гэдэг нь өдөр тутам харагдаж байгаа. Засгийн газар жишээлбэл Туулын хурдны зам төсөл дээр худалдан авах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг шалгаж, Сангийн яамны дүгнэлт гарсан. Тэр чигээрээ нуль гэмт хэрэг худалдан авах ажиллагаа нь. Тэгээд энэ бол анхнаасаа одоо ингээд хуулийн байгууллагад үнэн мөн тодорхой болох байх гэж бодож байна. Засгийн газрын дүгнэлт бол гарчихсан. Улсын Их Хурал дээр энэ асуудал дээр бол сонсгол явагдана гэж байгаа юм байна лээ. Засгийн газар энэ чиглэлээр шалгаж тогтоосон үйл баримт, дүгнэлтүүдээ гаргаж өгнө гэж бодож байна. Энхтүвшин гишүүн ахлаад сонсгол зохион байгуулна гэж байгаа. Бичиг нь өчигдөр надад ирсэн. Хариуг нь бэлдэж байна.

Таны асууж байгаачлан нууцад хамааруулах байдлаар би ялангуяа тусгай албаны зүгээс хууль зөрчсөн энэ нууцад авдаг асуудал бол байхгүй. Ялангуяа тагнуулын байгууллагын хувьд авах ёсгүй юмыг нууцад авдаг тийм үйл баримт ерөөсөө байхгүй. Энэ гол асуудал юун дээр гараад байна гэхээр төрийн нууц дээр биш албаны нууц дээр асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр албаны нууцад авах эсэхийг тагнуулын байгууллага ерөөсөө шийддэггүй. Харин ч тагнуулын байгууллагын хяналтгүйгээр, зөвшөөрөлгүйгээр албаны нууцад авч янз бүрийн үйл баримт хийсэн асуудлууд өнгөрсөн хугацаанд болсон учраас энэ тагнуулын байгууллагатай хамтарч нэг бүрчлэн энэ чинь албаны шалгалт хийгдлээ шүү дээ Засгийн газрын түвшинд. Энэ шалгачихсан. Би ганцхан жишээ ярихад энэ Оюу толгой, Эрдэнэс Оюу толгой дээр 20 сая доллар авсан үйл баримтууд бүгд тагнуулын байгууллагын зөвшөөрөлгүй, нууцад авах ийм дүгнэлт хянуулаагүй зүгээр ингээд нууцын тамга дараад ингээд хоорондоо

харилцсан үйл баримтууд гарч ирж байгаа юм. Тэгээд тэр дотроо ингээд албан бичгээр хэрүүл хийж байгаа юм. Тэгж ярих юм бол чи хууль зөрчиж энэ мөнгийг авч байна, чиний зарцуулж байгаа мөнгө чинь хууль бус, чинийх болохоор хууль бус гээ ингээд компанийн захирал, Хууль зүйн дэд сайд хоёр нь албан бичгээр ингээд нууцын тамгатай бичгээр хэрэлдээд суугаад байгаа байхгүй юу одоо ингээд харахад.

Тэр байтугай тэр 20 сая долларын зарцуулалт дотор Засгийн газрын хуралдаанаар мөнгөн дүнгүй шийдвэрийн төслийг оруулаад, албажаад гарахдаа мөнгөн дүнтэй болоод албажаад гарчихсан ийм асуудлууд тогтоогдож байна. Тэгэхээр энэ албаны нууцын тамгыг дур зоргоороо ашигладаг, өөрсдийн үзэмжээрээ ашигладаг ийм нөхцөл байдлууд бол хавтгайрсан байна дээрээсээ эхлээд.

Тийм учраас энэ нууцын хуулийг хууль, тогтоолоор цэгцэлье гэж байгаагийн цаана авлига, цаашдаа ийм гэмт хэрэгтэй Монгол Улсын Засгийн газар эвлэрэхгүй байх, энэ улс төрийн хүсэл эрмэлзлийг зөвхөн амаар биш бодит үйлдлээр ингэж санаачилж оруулж ирж байгаа юм. Сая хэлсэнчлэн энэ бол 2025 оны 11 сард үзэл баримтлал нь батлагдаад өвөл Засгийн газар 1 сард хэлэлцэгдээд Их Хуралд өргөн баригдсан ийм санаачилга төсөл байгаа. Энэ хуулийг батлах нь өөрөө иргэдийн мэдэх эрх, Монгол Улсын авлигатай тэмцэх үзүүлэлтэд ч гэсэн эергээр нөлөөлнө. Монгол Улсын цаашдаа санхүүгийн энэ олон улсын гаргадаг үзүүлэлтүүдэд ч гэсэн энэ бол бас эергээр нөлөөлөх байх гэж ингэж бодож.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд аа би сая бас яг хэд хэдэн тодорхой асуултыг асуулаа. Болохгүй бол ажлын хэсгүүд нэмээд хариулаадахъя. Яг хуулийнх нь төсөл дээрээ юу гэж хийсэн юм бэ гэдэг асуудал.

Нэгдүгээрт, хууль бусаар нууцалсан үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох юм уу, үгүй юм уу? Хууль бусаар нууцад авсан этгээдүүд дээр гэмт хэргийн хариуцлага оногдуулах юм уу үгүй юм уу гэдэг асуудал байгаа. Нэгдүгээрх.

Тэгэхээр саяын наад төрийнх байна уу, албаных байна уу хууль зөрчиж нууцад авсан этгээдүүдтэй холбоотой хариуцлагын санкцыг бид нар чангаруулж сайжруулж байгаа юм уу үгүй юм уу? Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь төрийн нууцад авдаг төсвийн зардлуудыг нарийвчилж зохицуулалт хийж чадаж байгаа юу? Яг ийм зүйл, заалттай зардлууд орно гэдгийг нарийвчилж хийж чадаж байгаа юу. Эргээгээд ямар ч тохиолдолд ямар ч төрийн нууцад орсон үйл ажиллагаа болоод түүнтэй холбоотой зардлууд дээр тодорхой хэмжээний бас хөндлөнгийн хяналт бол байх ёстой гэж хараад байгаа юм. Мэдээж Улсын Их Хурал нууцад авсан төсвийг нууцаар баталсан асуудлууд байгаа бол мэдээж аудитын байгууллага нь бас нууцаар ороод хянадаг, шалгадаг тодорхой хэмжээний хяналт бол байх ёстой гэж хараад байгаа юм.

Гуравдугаарх нь энэ. нууцлах хугацаа бас тодорхой хэмжээгээр их урт байдаг. Энийг ер нь богиносгох боломж бололцоо байгаа юм уу байхгүй юм уу? Нууцлах энэ үйл явцыг бас маш нарийн хяналттай болгох гэдэг асуудлыг бас яриад байгаа юм. Энэ дээр нэмэлт хариулт авъя.

Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Улсын нууцад хамаарах төсөвтэй холбоотой асуудал бол үндэсний аудитын байгууллага бол аудит хийгддэг. Энэ аудит хийгдэх нууцын шалгагдаж итгэмжлэгдсэн мэргэжлийн аудиторууд аудит хийгддэг. Энэ аудитын дүгнэлт бол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороонд бол танилцуулагддаг. Энэ эрх зүйн орчин нь бүрдсэн байгаа. Аудит хийх журам нь бол юугаар батлагдсан маш нууцын зэрэглэлтэй батлагдсан байдаг. Мэдээж Улсын Их Хурлаас энд тавих хууль тогтоомжууд бол мэдээж боловсронгуй цаашдаа болох шаардлагатай. Төсвийг боловсруулах Улсын Их Хуралд өргөн барих, мөн Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороогоор энэ асуудлыг хэлэлцэх, шийдэх журам нь мөн маш нууцын зэрэглэлтэй бас батлагдсан. Эрх зүйн орчингүй биш энэ эрх зүйн орчинтой. Энэнийхээ дагуу явдаг, хяналтад байдаг, жил болгон тайлан гардаг, аудит хийгддэг, тэр зөрчил, дутагдал гарсан хүмүүстэй албан тушаалтан юмнуудтай хариуцлага яригддаг ийм хууль тогтоомжтой явж ирдэг. Тийм учраас энэ бол бас огт ийм эрх зүйн орчингүй, зохицуулалтгүй ийм асуудал биш байгаа.

Г.Тэмүүлэн: Хууль бусаар нууцалсан үйлдэл болоод этгээд дээр тооцогдох хариуцлага байна уу? Хууль зүйн яам Мөнх-Эрдэнэ. Индрийн микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоор Төрийн нууцын тухай хуулийг зөрчиж нууцалсан нууцад авсан тохиолдолд Зөрчлийн хуулиар хариуцлага тооцож байгаа. Торго шийтгэл ноогдуулж байгаа. Мөн хэрвээ энэ үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй байвал албан тушаалаа урвуулан ашиглах бусад байдлаар энийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх ийм боломжтой байгаа. Одоо үйлчилж байгаа эрх зүйн орчин, мөн захиргааны хариуцлагын хувьд бол одоо энэ Төрийн нууцын тухай хуулийн 7 дугаар бүлэгтээ Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэл Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагын саналын дагуу албан тушаалаас нь огцруулах, албан тушаалаас нь албан тушаал бууруулах, төрийн албанаас халах, мөн цалингийн хэмжээг 3 сар хүртэлх хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах гэх мэт хариуцлага хүлээлгэж байгаа. Тийм, бид бас энийг хадгалаад оруулж ирж байгаа юм. Тэгж байгаа, тийм. Ер нь бол гол ялын бодлогын хувьд өөрчлөгдөж байгаа, чангарч байгаа гол асуудал бол төрийн нууцын төрийн нууц, маш чухал нууц, онц чухал нууцыг задруулах үрэгдүүлэх тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг эрүүгийн хувьд Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчимд нийцүүлэн, тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэм буруугийн хэлбэрт тохирсон ийм байдлаар хуульчилж оролцож байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Гишүүд нэрсийг авъя.

Ганбат гишүүнээр тасалъя. Анар гишүүн үг хэлнэ.

Ч.Анар: Энэ хуулийн албаны нууцыг хасаж байгаа хэсэг бол үзэл баримтлалын хувьд бол зайлшгүй дэмжих ёстой. Энэ бол завхралыг цэгцлэх маш том суурь өөрчлөлт байна гэж харж байна. Төрийн нууцын жагсаалтыг батлахдаа бол их хурлаар гэхээсээ илүү Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр хаалттай горимоор хэлэлцдэг байвал илүү зохистой юм болов уу гэсэн саналтай байна. Тэгэхгүй бол Их Хурлаараа хэлэлцэх юм бол нууц маань нууц байж чадахаа болино гэсэн санаа зовнил байна. Бид нар жагсаалтаа, нууц

жагсаалтаа Их Хурлаараа нээлттэй ч юм уу горимоор баталчхаад тэрийгээ юуг нь нууц гэж үзэх вэ?

Нөгөө талаасаа энэ одоогийн энэ албаны нууцад сая бид нар бүгдээрээ л хөндлөө шүү дээ. Эдийн засгийн агууламжаараа тоо баримтгүй нуучихсан, хэн нууцад авсан нь тодорхойгүй, бүртгэлгүй, Их Хурал хянан шалгах ажиллагаагаа хийхээр нууц гэдэг байдлаараа тэр асуудалтай танилцсан биш ярьж болохоо больчихдог. Тэгээд энэ хууль бусаар нууцад авсан энэ өнгөрсөн хугацааны асуудлуудыг хариуцлага тооц тооцох ёстой. Маш их юм байгаа шүү дээ түрүүн Энхбаяр сайд дурдаж байгаа. Тэгээд энэ дээрээ дахин хянан шалгах үйл ажиллагаагаа хийгээд хууль бусаар нууцад авсан маш олон төсөл, хөтөлбөрүүдийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох үйл ажиллагаагаа явуулаасай, битгий зогсоогоосой гэж хүсэж байна.

Хамгийн сүүлд нь бол энэ өргөн мэдүүлсэн хуулийн төсөл ажлын хэсгийн хүрээнд бол мөн хэлэлцүүлгийн явцад засварлах шаардлагатай байх. Нэгдүгээрт үг, үсэг, логикийн болоод хууль зүйн техникийн бол маш их зөрчилтэй. 1 энэ хуудсан дээр л гэхэд л эрээлтэл зөрчлүүд гарч ирж байна шүү. Тэгэхээр энэ хуулийн төслийг бол дэмжиж байна.

Г.Тэмүүлэн: Анар гишүүнд баярлалаа. Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Ямар утгаараа дэмжиж байгаа гэхлээр энэ үнэхээр жишээлбэл арилжааны шинж чанартай гэрээ, хэлэлцээрүүдийг нууц болгоод оруулж ирээд сүүлдээ шүүх дээр ч бүр хаалттай хэлэлцээд байдаг байсан энэ эрх зүйн суурь нөхцөл байдал арилах ийм үүд хаалга нээгдэж байна гэж үзэж байгаа утгаараа би энийг бол их зөв юм явж байна гэж харж байна.

Яагаад гэвэл Монгол төр нууцлах юм байлгүй яах вэ. Гэхдээ огт нууцалж болохгүй нууц биш юмыг нууц гээд бүүр шүүх дээрээ хүртэл аваачиж байгаад нуугаад хэлэлцээд байдаг бол ард иргэд хэзээ ч хүлээж авах боломжгүй ийм нөхцөл байдлыг үүсгэж байсан. Тэгээд энэ амьдрал дээрээсээ ч энэ нь нөгөө нотлогдоод болохгүй болохлоор энийг ингээд өөрчлөөд оруулж ирж байгаа энэ нь зөв гэж бодож байна. Зүгээр энэ дээр нэг юмыг хэдүүлээ бас бодох хэрэгтэй. Ер нь бол энэ Нууцын тухай хууль энэ чинь хууль хэлэлцэж байгаа болохоос нууц хэлэлцээгүй байна шүү дээ. Тийм учраас Нууцын тухай хууль ил хэлэлцэгдэх ёстой.

Тэгэхгүй Нууцын тухай хууль нь өөрөө нууц болчихлоор юуг нууц гэж хүн мэдэх болох юм. Тэгэхлээр энэ чинь жишээлбэл зэвсгийн складууд байршил нь нууц байж болно. Тэгээд энийг энийг нууц гэдгийг хэн ч мэдэж байгаа. Харин яг хаана байгааг нь яриагүй байгаад байна шүү дээ. Энэ мэдээлэл бол нууц байна шүү. Цэргийн тоо нууц байна шүү. Сум, зэвсгийн тоо нууц байна шүү. Тэгэхлээр юуг нууц байхаа мэдээд хүн санаандгүй тэр мэдээллийг авчихсан байхад би юуг гаргаж хэлэхгүй байх ёстой вэ, эргээд би яг төрийн нууцаар бол би санаандгүй олоод мэдчихсэн байсан ч би хариуцлага хүлээчих нь байна шүү гэдгээ мэдэхийн тулд энэ хууль нь бол өөрөө ил хэлэлцэгдэх ёстой гэж би бодож байгаа юм.

Гэхдээ Байнгын хорооныхондоо бас хандаад хэлэхэд зарим дандаа нууц гэдэг чинь бид нар нууц гэхлээр ертөнцийн аймаар нууц юм байдаг гэж бодоод байдаг. Зарим үхлүүд нь ч бас аягүй энгийн зүйл байдаг шүү. Тийм учраас харин

ёстой энэ Байнгын хороо эд нар дээр хэлэлцэж байхдаа нууцлах ёстой юман дээрээ бол яг энийгээ ярьж байгаад нууц горимоор бол хэлэлцээд явдаг байх ёстой. Тэгэхгүй ийм энгийн юмыг энэ нууц биш гээд. Тэгээд дараа нь тэрний гарах үр дагавраа бид нар чинь жижиг улс шүү дээ пянгаа даахгүй байх тохиолдол бол гарч байсан юм шүү. Би яг өөрийнхөө амьдрал дээр мэднэ. Энэ наадхаа хаалттай хэлэлцээ гээд байхад л нэг л нээлттэй хэлэлцдэг хүмүүс болж байгаад хэлэлцүүлгийн явцад баахан мэдээлэл гарчхаад тэрийгээ дараа нь хянаж чадахгүй энэ нь өөрөө маш хүнд нөхцөл байдал руу Монгол Улсыг оруулж байсан нөхцөл байдал гарч байсан.

Тэгэхлээр тэр мэтийн яг яах аргагүй нууцлах юмнууд дээрээ бол зоригтой нууцлаад хэлэлцээд явж байх ёстой. Энэ хууль бол ерөнхий хууль яригдаж байгаа учраас энэ нь бол ил хэлэлцэгдээд явах ёстой л гэж бодож байна. Би энэ хуулийг дэмжиж байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Цогтбаатар гишүүн. Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Мэдээж хэрэг улс орон л юм чинь нууцтай л байлгүй яах вэ. Хувь хүн ч гэсэн байгууллага ч гэсэн нууцтай л байх ёстой л доо. Харин манай улсын хэмжээнд энийг авч хэрэгжүүлж байгаа нь үнэхээр харамсмаар байгаа байхгүй юу. Энэ нууц нь бол ерөөсөө авлигачдын авч байгаа, хулгайч нарын хийж байгаа юмыг л нууцалдаг л ийм л арга хэрэгсэл болсон. Газар газрын хулгайч нар бол ганц нэгээрээ л энэ юмаа нууцлаад ингээд яваад тэр нь баригдаад орон шоронд ордог бол манайд бол үгүй. Нам дамжсан бүлэглэл энийгээ чөлөөтэй хийдэг ийм л болчихоод байгаа. Тэгээд арга ядаад л ийм хууль нь ингээд л оройтож оруулж ирээд л ингээд явж байна. Дэмжиж байна. Бас үр дүн гарах юм уу үгүй юу тэгээд л харъя л даа. Тэгээд энэ улс орон чинь энэний чинь үр дүнд ингээд энэ хэд нэг болж байгаа юм шиг. Учралын Засгийн газар учраа л олохгүй яваад байна л даа. Өмнө олон Засгийн газрууд авлига, хулгай, энээ тэрээ юмтайгаа тэмцэхгүй байж байгаад л дууссан. Энэ Ардын нам нь ч дуусаж байна. Энэ олон намууд ч дуусах шинжтэй болчихлоо.

Тэгээд энэ арга, эвээ нөгөөдүүл нь олчихлоо шүү дээ. Бүгдийг нь барьцаалаад л өдөр хоног өнгөрөөсөн ийм нэг Засгийн газартай. Тэгээд ард түмнийг хар л даа амьдрал нь 30 хувь нь нэн ядуу, 50 хувь нь ядуу. 200, 300 мянган хүмүүс дайжчихсан ийм байдалтай болчихсон байна. Энгийн иргэн шударга зөв хууль хэрэгжүүлдэг хүн бол энэ улс оронд чинь амьдрах ямар ч боломж, бололцоогүй болгож байна. Энийг анхаарч ажилламаар байна. Тэгээд бүгдээрээ барьцаанд орчихсон. Бие биеэ барьцаалчихсан. Ганц нэгхэн сайд л бас нэг хэлэх юм, дуугарах юм ярих юм. Тэр нь ямар ч амжилтгүй. Ийм л болчихоод байгаа юм даа. Тэгээд энэ чуулган дээр чи ямар ч хүнд сурталтай болчихсон юм, бас нэг үг хэлээд санал бодлоо дэвшүүлчих боломж олдохгүй юм. Бололцоо олдохгүй юм.

Тэгээд Аюулгүй байдал байнгын хороон дээр бас нэг ганц нэг юм хэлчихье. Энэ улс орон бол уул нь Монгол Улс чинь Монгол Улс шиг улс байсан юм шүү дээ. Байх юм. Хамгийн уул нь ардчилсан улс орон юм байгаа юм шүү дээ. Одоо манай улсын бодлого бол олон тулгуурт, тэр энхтайван ч ийм бодлого эрхэмлэдэг улс орон. Одоо энэ Украин, Оросын дайн явж байна. Сүүлийн үед бас нэг зогсчих боломж бололцоотой болж эхэлж байна. Тэгэхээр энэ Зеленский Ерөнхийлөгч, Путин Ерөнхийлөгч хоёрыг бас уулзалтыг нь товлочих газар хайгаад байх шиг байна. Тэгэхээр манайх бол санал, санаачилга гаргаад Улаанбаатар зохион

байгуулж болох байхгүй юу. Тэгвэл бид нарын нэр хүнд ямар байх вэ энэ чинь Зеленский чинь Эрдэнэт хотод аав, ээж нь ажиллаад энэ ГОК-ыг бүтээн босгож байсан ийм л хүмүүс. Манай Путин Ерөнхийлөгчийг бол энэ янз бүрийн хоригт орчихсон Орос орон Путин ерөнхийлөгч маш хүнд байхад бол бас уриад улс орондоо айлчлуулаад ингээд явуулж байсан. Тэрийгээ ч олон олон улсын байгууллагад энэ улс орнууд бид нар зөв тайлбарлаж байсан. Энэ энхтайван ч энэ асуудлыг ингээд хийгээд хэрэгжүүлээд явмаар байх юм. Бид нар дандаа баргар юм ярьж баймааргүй байна. Бас тэгээд энэ хоёр улс хоёулаа л тэгээд манай Их Монгол улсын харьяанд л байсан улс шүү дээ тийм. Тэгээд хоёр Славян ах, дүү нар л байж байгаа шүү дээ. Энийг нь энхтайван энэ найрамдлын харилцааг нь бид нар тогтоогоод өгчих. Тэрэнд нь энэ Улаанбаатар хотоос санал, санаачилга болгоод дэвшүүлэхэд болохгүй юм байхгүй шүү. Нөхдүүд минь жоохон санал, санаачилгатай ажил хийж баймаар байх юм. Заавал би л хэлж байх ёстой юм шиг.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулж эхэлье. Санал хураалтад бэлтгэгцгээе. Гишүүд санал хураалтад бэлэн байна уу? Тэгье туршилтын санал хураалт нэгийг явуулаад үзье. Хамгийн анхны санал хураалт байгаа. Туршилтын санал хураалт. Санал хураалтыг явуулъя.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Анхааралтай байгаарай. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ. Дагасан дагасан 44 хууль байна. Тус бүрчлэн явах юм байна. Ер нь тийм байна. Тэгэхээр Дэгийн хууль дээр ер нь бид нар бас энийг бас анхаарах л ёстой асуудлууд. Тэртээ тэргүй чуулган дээр нэг бүрчлэн хураадаг, хэлэлцдэг асуудлыг Байнгын хороо бол бүхэлд нь уг нь бас хэлэлцээд шийддэг ийм зохицуулалт бол зайлшгүй байх ёстой гэж бас үзээд байгаа. Одоо ямар ч байгаа дэгийнх нь зохицуулалтаар явъя. Санал хураалт явуулахаар байгаа.

1 дүгээрт, Төрийн нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал хураалт Архив болон албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

3.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал.

52.6 хувиар дэмжигдлээ.

4.Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ. Гишүүддээ баярлалаа.

5.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

6.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

7.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

8.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг. 57.9 хувиар дэмжигдсэн байна.

8.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

9.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

10.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

11.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

12.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

13.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

14.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэдэг. томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

15.Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

16.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

17.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

18.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэдгээр томьёо томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.2 хувиар дэмжигдлээ.

20.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

21.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

22.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ер нь тийм л болчхоод байна. 57.9 хувиар дэмжигдлээ.

23.Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

24.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

25.Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

26.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

27.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

28.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

29.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

30.Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

31.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

32.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Одоо 10-аад байна. 57.9 хувиар дэмжигдлээ.

33.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

34.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

35.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

36.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

37.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

38.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

39.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

40.Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

41.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

42.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

43.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

44.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

45.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлахынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

Ингээд Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилох ёстой байгаа. Хэн илтгэх вэ? Анар гишүүн илтгэе. Дараагийн асуудалдаа орцгооё.

16.02 цаг

Гурав дахь асуудал. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд адил байгаа. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр сайд танилцуулна. Энхбаяр сайдыг микрофонд урьж байна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаараагүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан.

Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох зорилгоор Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Улсын Их Хурлаас 1995 он, 2004 онуудад баталж байсан Төрийн нууцын тухай хуулийн бүтцийн жишгийг баримтлан төрийн бодлогын хүрээнд 20, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хүрээнд 5, батлан хамгаалах хүрээнд 70, тагнуул, сөрөг тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд 62, мэдээллийн аюулгүй байдал бол болон бусад хүрээнд 43, нийтдээ 200 мэдээллийн жагсаалтыг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахдаа төрийн нууц хариуцсан 45 байгууллага бас санал авч, ирүүлсэн 762 мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээллийг үндэслэлгүйгээр нууцлах, салбар байгууллагын хэмжээнд хэт өргөжүүлэх эрсдэлийг хумих, үндэсний аюулгүй байдлын шинэ болон бодит аюул заналыг харгалзан үзсэн болно.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар дараах үр дүнд хүрэх ач холбогдолтой.

1.Төрийн нууцын жагсаалтыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар батлах эрх зүйн үндэс бүрдэнэ.

2.Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан салбар байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах 574 мэдээллийг 200 болж буулгана.

3.Үндэсний нууц хамгаалах тогтолцоо бэхжиж, мэдээллийн аюулгүй байдлыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх хууль хэрэгжилтийн нэгдмэл байдлыг хангах үндсээр бүрдэх болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайдад баярлалаа. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Шууд санал хураалтад бэлтгэцгээе. Хосбаяр гишүүн ороод ирлээ. санал хураалтаа явуулъя. Бүгд санал хураалтад бэлтгэцгээгээрэй. Санал хураалтад бүгд бэлтгэсэн байх тээ?

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулах гишүүн байна уу чуулган дээр? Энхтүвшин гишүүнээр томилъё. Дараагийн асуудалдаа орцгооё.

16.11 цаг

Төрийн нууцын тухай хууль хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл гишүүн танилцуулна. Цогтгэрэл гишүүнийг микрофонд урьж байна.

О.Цогтгэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсад 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо эрх зүйн үндсийг тавьсан.

Улмаар 2016 оны 12 дугаар сард Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг тус тус хүчингүй болгож, төрийн тухайн

харилцааг зохицуулж байсан харилцааг зохицуулах зорилгоор Төрийн болоод албаны нууцын тухай хуулийг баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэгт улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төрийн нууцыг хуулиар тогтоон хамгаална хэмээн заасан. Ардчилсан нийгэмд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа олон нийтэд аль болох, ил тод, нээлттэй, энэ талаарх мэдээлэл хүртээмжтэй байх ёстой. Хэдий тийм ч нийтийн ашиг сонирхол буюу улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, хэв журмыг хангах зорилгоор тодорхой мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох замаар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлаж болохоор Үндсэн хуульд заасан.

Гэвч Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар бус Засгийн газрын тогтоолоор баталдаг болсон нь хэлбэрийн хувьд Үндсэн хуульд нийцэхгүйгээс гадна мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур, босго намсаж, үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хяналт байхгүй болсон. Сөрөг үр дагаварт нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газар нь мэдээллийг төрийн нууцад авахдаа Улсын Их Хурлын хяналтгүйгээр дур зоргоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн үүнийг дагаад иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх хумигдаж хууль бус үйлдлүүдээ Засгийн газар өөрөө дур мэдэн нууцлах эрх зүйн үндэс бий болсон.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн дагуу төрийн нууцад хамааруулж байсан мэдээлэл 60 орчим байсан бол Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад авсан мэдээллийн тоо давхцалгүй тоогоор 500 гаран болж нэмэгджээ. Үүнээс гадна албаны нууц хэмээх ойлголтыг төрийн байгууллага нь төрийн байгууллагын нууц гэсэн ойлголтыг дотооддоо бүрдүүлэх болсон. Тодруулбал, төрийн байгууллагууд өөрийн байгууллага тус бүрдээ мэдээллийг нууцалдаг болсон нь нууцын талаарх ойлголтыг хавтгайруулж, иргэдийн мэдээллийг авах эрхийг боогдуулж, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд бас саад учирч эхэлсэн.

Компаниудын өндөр үнийн дүнтэй худалдан авалт оффтэйк гэрээ зэрэг олон нийтийн хяналтад байх ёстой үйл ажиллагааг төрийн болон албаны нууцын тухай ангилалд хамруулж ирсэн нь мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн хяналт, нээлттэй өрсөлдөөнд сонгон шалгаруулалтын зарчмыг бодитойгоор хязгаарлах нөхцөл бололцоог бүрдүүлсэн.

Үүний улмаас төрийн өмчит компаниудтай холбоотой олон тэрбум төгрөгийн авлига, албан тушаалын гэмт хэрэг ихсэж, төрийн өндөр албан тушаалтнууд болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд холбогдох тохиолдол нь хэвийн явдал боллоо.

Монгол Улс сүүлийн жилүүдэд авлигын төсөөллийн индекс, ардчиллын индекс, хэвлэлийн эрх чөлөөний индекс зэрэг олон улсын үнэлгээнүүдээр тогтмол ухралт хийж байгаа бөгөөд төрийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх шаардлага улам бүүр нэмэгдэж байна.

Тухайлбал, 2025 оны хуулийн засаглалын олон улсын индексээр Монгол Улс нийт 142 орноос 67 дугаар байранд эрэмбэлэгдсэн нь төрийн байгууллагын ил

тод байдал хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага өндөр байгааг харуулж байна.

Хуулийн төсөл Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар баталж, төрийн нууцыг тогтоох, ил болгох эрхийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалуулж, хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглох, төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн мэдээллийг албаны нууцад авах зориулалтыг хуулиас хасах зэрэгт чиглэсэн.

Ийнхүү Төрийн нууцын тухай хуулийн төслийн зорилт нь Монгол Улсын төрийн нууцад хамаарах үнэ төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төрийн нууцын тухай хуулийн төсөлтэй хамт Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд заасан төрийн нууцыг хадгалах, хамгаалах, хуулиар хүлээсэн үүрэггүй хүн төрийн нууцыг олж авсан нь төрийн нууцыг хууль бусаар олж авах гэмт хэрэгт хамтран оролцох шинжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхаар бас нэмэлт зохицуулсан.

Энэ нь иргэн, сэтгүүлч төрийн нууцыг хууль бусаар олж аваагүй бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх тухай зохицуулалт юм. Төрийн нууцад хууль зөрчсөн үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн баримтыг оруулахыг хориглохоор зохицуулсан.

Иймд Төрийн нууцын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Тэмүүлэн: Хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг хийсэн Одонгийн Цогтгэрэл гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Төрийн нөөцийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдтэй холбогдуулаад оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Ариунболд Ардчилсан намын бүлгийн зөвлөх, Солонгоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр орж байгаа юм байна.

Хуулийн төслүүдтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Шижир гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Нэг дэх асуулт нь болохоор Засгийн газраас өргөн барьсан яг ижил агуулгатай хуулийн төсөл энэ таны өргөн барьж байгаа хуулийн төсөл хоёрын гол ялгаанууд нь юу вэ?

Хоёрдугаарт энэ ер нь бол энэ Төрийн нууцын тухай хууль маш чухал хууль. Үндсэн хуулиар олгогдсон иргэний мэдэх эрхийг хязгаарладаг, энэ нууцтай холбоотой энэ хуулиар хязгаарладаг энэ Нууцын тухай хуулиар. Тэгэхээр энэ хуулийг тодорхой болгох нь иргэний мэдэх эрхийг хангах маш том чухал ийм хууль байгаа. Тэгээд энэ дээр нэг ийм сүүлийн үед төрийн нууцаас гадна албаны нууц

гэж өргөжүүлснээс гадна олон улсын гэрээ гэдэг асуудал оруулж ирж энэ мэдэх эрхийг хязгаарлаж байгаа асуудлууд байна. Тэгэхээр энэ таны өргөн барьсан энэ хуулийн төсөл болон Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийн 3.3 дээр нь хоёулаа адилхан олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улс олон улсын байгууллагаас шилжүүлэн өгсөн төрийн нууцад хамаарах мэдээллийг хамгаалахад энэ хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ гээд.

Тэгэхээр өөрөөр хэлбэл, жишээлбэл, Үндсэн хуулиар газрын баялаг ард түмний мэдэлд гээд заачихсан мөртөө тэр баялаг нь ямар нөхцөлөөр яаж зарж байгаа гэдгийг нь төрийн байгууллагууд нь жишээлбэл хоорондоо бараг мэдээлэл авч чадахгүй хэмжээнд ингээд олон улсын гэрээ хийчихсэн. Тэгэхээр олон улсын гэрээгээр энэ Монгол Улсын иргэний эрхийг, жишээлбэл олгогдсон энэ үндсэн эрхийг хязгаарлаж байгаа ийм асуудлууд байгаад байна. Энэ дээр, энэ таны энэ олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гээд энэ олон улсын гэрээгээр бас энэ мэдэх эрхийг хязгаарлаад байгаа учраас энэ дээр та ямаршуу бодолтой байгаа юм? Энийг өөр байдлаар зохицуулах, энэ олон улсын гэрээнд бас тодорхой хэмжээний энэ шаардлагууд тавих ийм бололцоо боломж юу байгаа энэ талаар та мэдээлэл өгнө үү гэсэн ийм 2 асуулт байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хууль санаачлагч Цогтгэрэл гишүүн асуултад хариулъя.

О.Цогтгэрэл: Хуулийн төслийг нийтэд нь нэр бүхий 18 гишүүн хамт өргөн барьсан гэдгийг бас эхэнд нь хэлье. Засгийн газрын өргөн барьсан хувилбараас ямар ялгаатай вэ гэж байна. Бид бүгдийг өргөн барих нь цаг хугацааны хувьд Засгийн газрыг өргөн барихаас өмнө буюу 1 жилийн өмнө 25 оны хаврын чуулганаар Засгийн газрыг өргөн барихаас өмнө өргөн баригдсан. Одоо ингэж хамтатгаж хэлэлцэгдэж байна. Бас энэ ташрамд хэлэхэд ингээд Ардчилсан намын бүлгийн гишүүдээс маш олон хуулийн төслүүдийг өргөн барьдаг. Энэ бүгдийн дараа Засгийн газрын хувилбар өргөн барьж, энийг хамтатгаж хэлэлцэх, Засгийн газрын хувилбарын дараа нийлүүлж хэлэлцэх гэдэг яг өнөөдөр бас Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гээд энэ хуулиудын хэлэлцүүлэг ингэж явж байгаа нэг ийм зохисгүй, төрийн ажлын нэг ийм зохисгүй хандлага явж байгааг бас эхэнд нь хэлчихье. Нэгдүгээрт нь.

Яг одоо өргөн барьсан, бид нарын өргөн барьсан хувилбараас гол зүйлс бол Засгийн газар дараа өргөн барихдаа бараг адил байдлаар өргөн барьсан байна лээ. Нэгдүгээрт нь. Үндсэндээ Төрийн болоод албаны нууцын тухай хууль гэдгийг албаны нууцын гэдэг харилцааг хасаж, Төрийн нууцын тухай хуулиар бүгдийг зохицуулж, албаны нууцад гэдэг авах харилцааг хуулийн үзэл хуулийн хүрээнд хасах, мөн төрийн нууцад авахдаа парламентаар Улсын Их Хурлаар жагсаалтыг батална гэдэг үндсэн агуулга. Одоо байгаа ялгааны нь 2 ялгаа байна лээ. Одоо байгаад болохоор бид бүгд төрийн нууцыг хуулиар хамгаалах, хадгалах үүрэг хүлээгээгүй хүн төрийн нууцыг олж авсан бол энэ нь төрийн нууцыг хууль бусаар олж авах гэмт хэрэгт хамтран оролцсон шинжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэж.

Жишээ нь иргэн, сэтгүүлч төрийн нууцыг хуулиар хамгаалах үүрэггүй хүнийг үндсэндээ эрүүгийн гэмт хэргээр яллах нөхцөл байдал бүрдэж байгааг энэ бол буруу. Энийг дагалдуулаад Эрүүгийн хэрэг байцаан шийтгэх хууль зэрэг хуульд процессын шинэчлэлээр нэмэлтүүд бас орж байгаа. Бас төрийн нууцад хууль зөрчсөн үйлдэлд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэлд хүний

үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн баримтыг төрийн нууцад оруулахыг хориглоно гэдэг заалт давхцалгүй харагдаж байгаа гэдгийг хэлье.

Тэр олон улсын гэрээтэй холбоотой гишүүний асуултад манай ажлын хэсгээс Ариунболд зөвлөхийг хариулж өгөөч. Би бас тэр дээр тодорхой хариулт өгнө гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хариулъя. Индрийн микрофон өгье. Ариунболд зөвлөх. Индрийн микрофоныг өгье.

Н.Ариунболд: Баярлалаа. Энэ олон улсын гэрээг хуулиар соёрхон баталдаг. Өөрөөр хэлбэл тухайн олон улсын гэрээг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг учраас тэнд бол бас ямар гэрээнд нь нууцтай холбоотой асуудал орсон байгаа бол тэр Улсын Их Хурал өөрөө Улсын Их Хурлын гишүүд танилцаад тухайн асуудлыг хуулийн хэмжээнд хүлээн зөвшөөрөх үү үгүй юү гэдгээ шийдвэрлэх ийм боломжтой учраас энэ хуулийн зохицуулалт ингээд одоогийн хууль дээр ч байгаа, бидний төсөл дээр ч гэсэн орсон ийм чиглэлтэйгээр явж байгаа.

Жишээ нь хуулиар болон олон улсын гэрээгээр нууц байна гэдэг ийм зохицуулалтууд орж ирдэг л дээ. Жишээ нь шүүхийн процессын хууль дээр зөвлөлдөх тасалгааны санал нууц байна ч гэдэг юм уу. Энэ жагсаалтдаа нууц байна гэдэг ийм байдлаар орчихдог. Олон улсын гэрээн дээр ч гэсэн жишээ нь нэг талынх нь санал юм уу, хоёр талынх нь санал ч юм уу энэ нууц байх тухай ч гэдэг юм уу иймэрхүү асуудал орж ирж болдог. Тэрийг нь мэдээж хэрэг зөвхөн Засгийн газар өөрөө бат шийдэхгүйгээр Улсын Их Хурал тэрийг зөвшөөрөөд хууль соёрхон баталснаар хуулийн хүчин чадалтай болно гэдэг агуулгаараа Улсын Их Хурлаар орж хууль батлах хэмжээний хүчин төгөлдөр байгаа учраас энэ хуулийн зохицуулалтын 3-ын 3 төсөл орж ирж ингэж явдаг гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ариунболд зөвлөхөд баярлалаа. Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм, тэгэхээр энэ олон улсын гэрээгээр тухайлбал зүгээр бодитой сүүлийн яг бидний мэдэж байгаа жишээ бол Харбины гэрээ. Харбины гэрийн 5.6-д нь бол бараг Сангийн яам тэр үнэ тогтож байгаа процессыг нь мэдэхийн тулд Хятадын талаас асуухаар ийм заалт байгаа байхгүй юу. Энэ нь өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар иргэдэд олгогдсон яг мэдэх эрхийг хязгаарлаж байгаа зүйл, заалтыг олон улсын гэрээ болгож өргөтгөөд хил дамнуулаад ингээд бид нар эндээ бас яг яаж илүү тэр албаны нууцыг нь цэгцэлье гээд явж байхад олон улсын гэрээ гээд энэ нэг ийм зам болоод тийшээ аваачиж жишээлбэл бид нарын Монгол улсын иргэний мэдэх эрхийг өөр иргэний шинжтэй ийм олон улсын шинжгүй аж ахуйн шинжтэй ийм гэрээнүүдийг жишээлбэл ингээд нууцалж байгаа нь энэ бол бас цаашдаа бас зүгээр энэ нууцтай холбоотой хуулиуд дээр анхаарах ёстой юм байна лээ гэж бодогдсон. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тэгье Цогтгэрэл гишүүн асуултад хариулъя.

О.Цогтгэрэл: Тийм, Энхтүвшин гишүүний хэлж байгаа бол ингээд зарчмын хувьд маш зүйтэй л дээ. Тэнд байсан аж ахуйн харилцааг бид нар төрийн нууцад аваад яг энэнтэй холбоотой хэчнээн их хардлага сэрдлэг энэ нь өөрөө улс хоорондын харилцаанд ч сөргөөр нөлөөлөх түвшинд хүрч байгааг бид нар

бүгдээрээ харж байна. Зөвхөн сая ингээд өнөөдөр хийж байгаа мэдээллээр түрүүн хуульд танилцуулсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр сайд 570 баримт бичгийг төрийн нууцад авсан гэж байгаа юм. Тэгсэн тэндээс Эдийн засгийн хөгжлийн сайд болохлоор 800 баримт бичгийг төрийн нууцад авсан гэж байгаа юм. Бид нар дээр байгаа мэдээллээр 400 гаран гэж байгаа юм. Тэгэхээр хэдэн баримт бичиг төрийн нууцад авсныг хэн ч мэдэхгүй болтлоо дур зоргоороо, Засгийн газрын хоёр сайд нэг нь 570, нэг нь 800 баримт бичиг яг ингээд л ярьж байна.

Бид нарт өгсөн мэдээлэл дээр 400 гэж өгсөн. Зүгээр л энэний цаана энэ авлига, хулгай, олон олон дур зоргын үйлдэл гэдэг чинь өнгөрсөн хугацаанд юу болсныг хэчнээн их энэ авлигын үндэс, суурь, тэр шалтгаан хаана байсныг л энэ нөхцөл байдал харуулж байгаа ийм л цаг үеийн хувьд энэ хуулийг өөрчлөх тэр тусмаа Энхтүвшин гишүүний ярьж байгаа тэр аж ахуйн харилцааг төрийн нууцад авчихсан тэр нь ерөөсөө л бизнесийн харилцаа. Тэгээд л энэ бүгдийн цаана хэчнээн их худал хулгайг нуун дарагдуулах үүд хаалга, цонх бий болсныг л ингээд харагдуулж байна. Тэгэхээр та бүгдийг бас тэгээд энэ хуулийг дэмжиж нэгтгэж хэлэлцэж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Цогтгэрэл гишүүнд баярлалаа. Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Баяр наадам дөхөөд ч юм уу шинэ жил дөхөөд ирэхээр нэг ийм хуулийн хулгай ч гэдэг юм уу аль эсвэл иргэдийн анхаарал суларсан үед ийм сонин сонин ноцтой хуулиуд аягүй их орж ирж. Тэрний нэг нь энэ хууль юм байна лээ. 2016 оны 12 сард. Тэгээд энэ хуулиар албаны нууц гэдэг ойлголт нэмчихсэн. Албаны нууц гэдэг ойлголт нэмснээс хойш ингээд бүх юм нууц болчихсон. Одоо бид нарын энэ хэрэглэж байгаа энэ санал тоолох төхөөрөмж чинь хүртэл нууц. Мэдээллийг нь авъя гэхээр нууц. Хаанах худалдаж авсан юм гээд нууц. Хэдэн төгрөгөөр авсан гэхээр нууц. Мэдээллийг нь өгөөч гэхээр нэг хавтастай бичиг баримт бариад ороод ирдэг. Хэдэн төлбөрийн гүйлгээний бариад ороод ирж байсан жишээ нь. Тэгээд энэ байдал чинь өөрөө юу болоод байна вэ гэхээр иргэдийн итгэх итгэлийг нэг талаасаа нууцлаад байгаа бол төрд итгэх итгэлийг, бас нийгмийн бүхмдлыг нэмэгдүүлээд байгаа юм л даа.

Одоо ногоон автобусны худалдан авалт бас нууц. Оюу толгойн аудитын тайлан бас нууц, Оюу толгойн сонсгол хийгээд “Онтри” компаниас бичиг баримт гаргуулахаар Ашигт малтмалын ерөнхий газраас илээр явуулсан бичгээ нууц гээд бичээд явуулчхаж байгаа юм. Нууцын тамга дараад, албаны нууцын тамга дараад “Оюу толгой” компаниас. Төрийн байгууллагаас ил явсан мэдээллийг төрийн байгууллага нь буцааж явуулахдаа нууцлаад явуулчхаж байгаа байхгүй юу. Ингээд бүх юм нь нууц болчихсон. Ил юм бараг байхгүй болчихсон. Ил ганц гарсан юм нь нэг сэтгүүлчийг нууц материалыг олж авсан байна гэж ялласан. Нууц хадгалах үүрэгтэй хүн нь сугарч үлдсэн. Тэгээд ийм гажиг хуулийн тогтолцоо ийм эргүү балай хууль үйлчил гэж байдаг юм уу ер нь? Ер нь бол үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбар, цэрэг, цагдаа, тагнуул энэ хэдийнх юмыг л нууцалъя л даа. Бусдыг нь юуг нь нуугаад байдаг юм? Яагаад Мэдээллийн ил тод байдлын тухай хуультай мөртөө нөгөө талд нь бүх юмыг албаны нууцыг нь нуучхаж байгаа байхгүй юу. Нэг сумын, нэг аймгийн, нэг сумын Засаг дарга зүгээр иргэдийн мэдээллийн нууц гээд нуучихсан тохиолдол байгаа шүү дээ.

Нөгөө талаасаа энэ чинь төрийн байгууллагуудад ажил байгуулахад аягүй хүндрэлтэй болчхож байгаа юм. Нууцаар ирсэн бичгийг нууцаар хариулна.

Нууцаар ирсэн асуулт дээр нууц хариулт өгнө. Тэгээд нууц, нууц, нууц бүх юм нууц. Тэгээд бид нар ийм байдлаар ингээд л асуудалд хандаад л байгаа юм л даа гэдгийг хэлэх гэсэн юм. Тэгээд сүүлдээ нууц нь өөрөө улс төр болсон. Тэрийг нууцаас гаргалаа гээд л баатар юм уу, яасан юм, бүтээн байгуулалт хийчихсэн юм уу, нэг бол хөрөнгө оруулалт татаад авчирчихсан юм уу, ажил хийчихсэн юм уу бүү мэд.

Тийм учраас одоо тэр нүүрсний хэдэн оффтэйк гээд байгаа юм бүү мэд. Тэрийг ил гаргалаа л гэнэ. Цаана нь дахиад байгаа л гээд байдаг. Тэгээд хэнд ашиг сонирхол нь хэний талд үйлчилнэ тэрнийх нь талд нууц гаргадаг эрх мэдэлтэй хүмүүс нь ийм болчихсон. Бүгдийг нь л ил гарга л даа. Юуг нь нуугаад байгаа юм. Нууцлах юм юу байгаа юм? Тэгээд сүүлдээ энэ ингээд төрийн байгууллагуудын ажил чинь ингээд хоорондоо явахад бол аягүй хүнд болчихож байгаа байхгүй юу. Аягүй хүнд юм байна лээ. Жинхэнээсээ яг нууцаар бичиг авчихдаг, буцаагаад л хариулахад нууцаар явуулах болдог. Заавал нууцын эрхлэгч гээд л ороод ирдэг.

Тодруулчихъя. Бусад нь 4 минут, минийх сая 3 минутаар явчих юм. Тийм тэгээд ер нь бол ингээд бид нар ийм юмнуудаа аль болох ингээд нууцлахгүй бол ер нь хардлага, сэрдлэг, үл ойлголцол, бие биеэ улс төрийн шантайж хийдэг ийм байдал чинь дуусахгүй. Төмөр замын бүх гэрээнүүдийг нь ил болго нууц байгаа юм бол. Оффтэйк гэрээнүүд дээр бүх юмыг нь ил болго. Үгүй ер нь яахаараа байгууллагын худалдан авалтын гэрээг хүртэл нуучихдаг юм? Жишээ нь “Оюу толгой” компани Монголд Монголын төр 34 эзэмшдэг. Тайланг нь танилцуулах гэж зөвхөн Төсвийн байнгын хорооны гишүүдэд нууцаар гээд ингээд бусад гишүүдэд өгдөггүй биз. Тэгээд аудитын тайлан нь бас нууц. Үгүй ингээд бид нарт нээрээ нууцгүй юм гэж алга. Тэгээд энэ асуудлуудаа ер нь энэ Нууцын тухай хуулиараа ингээд нэг мөр цэгцэлж авахгүй бол энэ чинь өөрөө дахиад бие биеийнхээ эсрэг хийдэг улс төрийн аягүй том шантаажны нэг хэсэг боллоо шүү дээ. Нууцыг ил гаргалаа, нууцыг нь нууцад авлаа нэг ийм.

Г.Тэмүүлэн: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Санал хураалтаа бэлтгэцгээе. Гишүүд төхөөрөмжүүдээ идэвхжүүлээрэй, хуруугаа хийгээрэй, санал хураалтад бэлтгээрэй. Болж байна. Бүх гишүүдийнх орсон уу? Орчихсон уу? Болчихлоо 10. Санал хураалтыг явуулж эхэлье.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд саналаа өгөөрэй.

52.6 хувиар дэмжигдлээ. Баярлалаа. Дахиад хэдэн санал байгаа билээ. 40 орчим байгаа юм байна. Гялс санал хураалтаа явуулчихъя.

1.Төрийн болон албаны нууцын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

2.Төрийн нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

3.Архив болон албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

4.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

5.Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

6.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдлээ.

7.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.6 хувиар дэмжигдлээ. 57.9 хувиар дэмжигдлээ.

8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

9.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

10.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

11.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

12.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

13.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

14.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

15.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

16.Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

17.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

18.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

19.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

20.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

21.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

22.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

23.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

24.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

25.Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

26.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

27.Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

28.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

29.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

30.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

31.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

32.Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

33.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

34.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

35.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

36.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

37.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

38.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

39.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

40.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

41.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

42.Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

43.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

44.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

45.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

46.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.9 хувиар дэмжигдлээ.

Ингээд Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Хууль санаачилсан Цогтгэрэл гишүүд болоод 18 гишүүн санаачилсан гэсэн. Мөн ажлын хэсгийнхэнд баярлалаа. Илтгэгч гишүүнээр Шижир гишүүн яах уу? Тэгье, тэгээд чуулганд, нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг Шижир гишүүнээр томилж байна.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ. Баярлалаа гишүүд ээ.

16.45 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР